

Байгалийн нөөцийн үндэсний
парк байгуулах тухай

Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын зөвлөл "Байгалийн нөөцийн үндэсний парк байгуулах" тухай Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газраас ирүүлсэн холбогдох баримт материалтай ажлын журмаар танилцаад Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалын 3.5.1.4 болон 3.5.1.6-гийн заалтыг үндэслэн ЗӨВЛӨМЖ болгох нь:

Нэг. Монгол Улсын Их Хуралд:

1. Хангай, Хэнтий нурууд, Хөвсгөл нуур орчмын бүс нутгийг улсын нөөцөд авч байгалийн нөөцийн үндэсний парк байгуулах эрх зүйн орчныг бүрдүүлэх.

Хоёр. Монгол Улсын Засгийн газарт:

1. Хангай, Хэнтий нурууд, Хөвсгөл нуур орчмын бүс нутагт байгалийн нөөцийн үндэсний парк байгуулах тухай хуулийн төсөл болон холбогдох бусад хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулж УИХ-д өргөн мэдүүлж шийдвэрлүүлэх;

2. Хангай, Хэнтий нурууд, Хөвсгөл нуур орчмын бүс нутагт байгалийн нөөцийн үндэсний парк байгуулах ажлыг зохион байгуулах;

3. Хангай, Хэнтий нурууд, Хөвсгөл нуурын байгалийн нөөцийн үндэсний паркийн цогцолборт бүс нутгийн экологи-эдийн засгийн үнэлгээ хийх.